



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2023/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Улаанбаатар хот
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Б.Хуланхатан
Утас: 99008827

Цахим хаяг: www.open.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2023.04.05

№ 341

танай _____ -ны № _____ -Т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дадал сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 385,743.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгө, 317,533.9 мянган төгрөгийн авлага, 85,014.8 мянган төгрөгийн урьдчилгаа, 148,305.1 мянган төгрөгийн бараа материал, 6,541,349.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 7,477,946.4 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 536,348.9 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч, 714,539.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,258,171.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 92,730.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 89,483.8 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 89,463.8 мянган төгрөгийг зарцуулан үлдэгдэл 20.0 мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Дадал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар санхүүгийн тайланг 1,577,172.2 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 766.5 мянган төгрөгөөр дутуу олгосон

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАДАЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.МӨНХ-ОД ТАНАА

232330450

зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн ба зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах, Орон нутгийн ерөнхий орлогын дансанд татварын орлогын нэр төрлийг зөрүүлэн хааж, залруулга бичилт их хэмжээгээр хийж байгааг анхаарч ажиллах шаардлагатай.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	952,732.0	936,597.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	262,559.0	385,743.3
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	257,626.1	376,485.6
31210	Төгрөг	257,626.1	376,485.6
31211	Төрийн сангийн харилцах	257,626.1	375,237.3
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	-	1,248.3
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	4,932.9	9,257.6
33	АВЛАГА	307,776.1	317,533.9
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	53,748.1	-
33500	Бусад авлага	-	10,000.0
33510	Байгууллагаас авах авлага	-	10,000.0
33600	Зээлийн авлага	254,028.0	307,533.9
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	254,028.0	307,533.9
33612	Хувь хүмүүст олгосон зээл	254,028.0	307,533.9
34	УРЬДЧИЛГАА	-	85,014.8
34600	Урьдчилж гарсан зардал	-	85,014.8
35	БАРАА МАТЕРИАЛ	382,397.0	148,305.1
35100	Түүхий эд материал	27,044.7	-
35110	Тусгай зориулалттай материал	6,107.0	-
35130	Эм боох материал	20,937.7	-
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	5,705.3	-
35400	Хангамжийн материал	347,473.1	120,131.2
35410	Бичиг хэргийн материал	4,154.5	1,298.5
35420	Аж ахуйн материал	302,047.5	105,527.4
35430	Сэлбэг хэрэгсэл	14,260.2	13,305.2
35440	Түлш, шатах тослох материал	1,455.0	-
35460	Хүнсний материал	15,631.2	-
35470	Бусад хангамжийн материал	9,924.7	-
35600	Мал амьтад	2,173.9	28,173.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,464,347.1	6,541,349.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,464,347.1	6,541,349.4
39200	Биет хөрөнгө	6,729,523.1	5,429,553.4
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,225,058.6	5,453,011.3
39202	Хуримтлагдсан элэгдэл	(729,018.9)	(556,186.7)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	415,273.0	216,588.8
39204	Хуримтлагдсан элэгдэл	(158,039.4)	(110,018.3)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,049,354.6	555,471.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	(329,753.3)	(183,754.3)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	298,892.3	107,822.7
39208	Хуримтлагдсан элэгдэл	(125,379.9)	(53,382.0)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	61,041.4	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,764.4	15,500.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31,764.4)	(15,500.0)
39217	Ном	22,094.7	-
39300	Биет бус хөрөнгө	734,824.0	1,111,796.0
39301	Програм хангамж	1,550.0	1,300.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	(810.0)	(820.0)
39303	Бусад биет бус хөрөнгө	734,084.0	1,111,316.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,417,079.1	7,477,946.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,612.6	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,612.6	-
41300	Өглөг	10,612.6	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,612.6	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,406,466.5	7,477,946.4
51	Засгийн газрын хувь оролцоо	8,406,466.5	7,477,946.4
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,396,584.7	1,231,548.0
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	-	1,231,548.0
51200	Хуримтлагдсан үр дүн	4,752,576.9	6,063,137.3
51210	Өмнөх үеийн үр дүн	4,642,968.2	6,941,811.9
51220	Тайлант үеийн үр дүн	109,608.7	(878,674.6)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	257,304.9	183,261.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,417,079.1	7,477,946.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,518,181.1	4,803,978.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	222,923.9	647,001.8
110	Орлогын албан татвар	68,751.3	473,719.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	68,751.3	473,719.0
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	-	409,524.8
110002	Үйл ажиллагааны орлого	9,545.8	6,917.3
110003	Хөрөнгийн орлого	50,662.3	36,963.5
110004	Хөрөнгө борлуулсны орлого	8,543.2	20,313.4
113	Хөрөнгийн албан татвар	48,199.2	46,176.6
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	7,527.2
113002	Бууны албан татвар	2,850.0	2,970.0
113004	Малд ногдуулах албан татвар	45,349.2	35,679.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,973.3	127,106.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,985.5	31,372.7
118001	Улсын тэмдэгтийн хураамж	5,393.5	4,564.0
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10,912.6	11,587.5
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,679.4	15,221.2
1181	Газрын төлбөр	3,885.1	25,618.6
118101	Газрын төлбөр	3,885.1	25,618.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	76,102.7	70,114.9
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	74,062.8	48,775.2
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,039.9	21,335.7
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	4.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	289,028.3	3,305,418.3
120	Нийтлэг татварын бус орлого	289,028.3	3,305,418.3
120003	Торгуулийн орлого	16,256.5	17,898.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	261,116.8	3,122,622.6
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,121.1	1,748.3
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	239,853.8	3,114,781.7
1200046	Зээлийн хүүгийн орлого	3,141.9	6,092.6
120009	Бусад орлого	11,655.0	164,897.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,006,228.9	851,558.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,776,605.3	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,776,605.3	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	280,044.3	89,483.8
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,208.8	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	183,450.5	83,431.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,636.9	6,052.6
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	53,748.1	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	919,348.1	762,074.9
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	799,469.3	536,348.9
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	119,878.8	225,726.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,231.2	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,231.2	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,279,611.5	1,423,617.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,279,611.5	1,423,617.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,150,156.9	1,369,681.1

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,707,918.6	389,738.8
210101	Үндсэн цалин	1,262,768.8	221,896.2
210102	Нэмэгдэл	314,398.5	60,917.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,689.0	3,833.0
210104	Урамшуулал	78,558.9	8,916.4
210105	Гэрээт ажлын хөлс	47,503.4	94,175.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	223,488.7	49,069.3
210201	Тэтгэврийн даатгал	155,745.3	33,631.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,211.4	3,925.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,665.4	3,122.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,341.2	762.8
210205	Эрүүл мэндийн даатгал	33,525.3	7,627.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	278,895.4	374,241.7
210301	Гэрэл, цахилгаан	29,725.1	44,474.5
210302	Түлш, халаалт	248,250.3	328,687.2
210303	Цэвэр, бохир ус	920.0	1,080.0
2104	Хангамж, бараа материалын зардал	140,143.0	42,548.1
210401	Бичиг хэрэг	11,409.5	6,144.7
210402	Тээвэр, шатахуун	56,385.4	27,084.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,288.7	3,832.3
210404	Ном, хэвлэл	19,342.4	191.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,404.8	180.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	44,312.2	5,115.2
2105	Нормативт зардал	170,093.9	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	92,736.1	-
210502	Хоол, хүнс	67,120.1	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,237.6	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,687.2	45,690.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,874.0
210604	Урсгал засвар	19,687.2	39,816.9
2107	Томилолт, зочны зардал	12,140.4	14,753.3
210702	Дотоод албан томилолт	12,140.4	14,753.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	88,452.0	138,538.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	78,020.3	131,249.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,204.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,331.6	661.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	436.7	560.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132.0	176.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200.0	250.0
210807	Газрын төлбөр	1,127.3	5,641.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	509,337.7	315,100.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,318.7	75,259.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	22,479.1	3,642.5
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	413,539.8	236,197.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	129,454.6	53,936.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	12,807.5
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	12,807.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	80,169.4	41,108.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	24,256.3	9,522.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,644.1	15,398.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,269.0	16,188.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	20.0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	20.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,285.2	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,285.2	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	238,569.6	3,380,361.6
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	5,499.2
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	5,499.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	128,960.9	4,264,535.4
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	8,513.1	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	109,064.5
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	120,447.8	3,874,790.5
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	280,680.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	109,608.7	(878,674.6)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,328,001.0	1,690,166.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	222,923.9	647,001.8
110	Орлогын албан татвар	68,751.3	473,719.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	68,751.3	473,719.0
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	-	409,524.8
110002	Үйл ажиллагааны орлого	9,545.8	6,917.3
110003	Хөрөнгийн орлого	50,662.3	36,963.5
110004	Хөрөнгө борлуулсны орлого	8,543.2	20,313.4
113	Хөрөнгийн албан татвар	48,199.2	46,176.6
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	-	7,527.2
113002	Бууны албан татвар	2,850.0	2,970.0
113004	Малд ногдуулах албан татвар	45,349.2	35,679.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	105,973.3	127,106.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	25,985.5	31,372.7
118001	Улсын тэмдэгтийн хураамж	5,393.5	4,564.0
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10,912.6	11,587.5
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,679.4	15,221.2
1181	Газрын төлбөр	3,885.1	25,618.6
118101	Газрын төлбөр	3,885.1	25,618.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	76,102.7	70,114.9
118201	Ойн нөөц ашигласны төлбөр	74,062.8	48,775.2
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,039.9	21,335.7
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	4.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	146,596.4	191,605.6
120	Нийтлэг татварын бус орлого	146,596.4	191,605.6
120003	Торгуулийн орлого	16,256.5	17,898.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	118,684.9	114,809.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,563.8	67,086.7
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,121.1	1,930.4
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	45,792.7
120009	Бусад орлого	11,655.0	58,897.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,958,480.8	851,558.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,776,605.3	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,776,605.3	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	232,296.2	89,483.8
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,208.8	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189,450.5	83,431.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,636.9	6,052.6
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	919,348.1	762,074.9
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	799,469.3	536,348.9
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	119,878.8	225,726.0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	30,231.2	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,231.2	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,892,675.7	1,251,477.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,892,675.7	1,251,477.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,757,770.7	1,150,524.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,698,731.5	389,738.8
210101	Үндсэн цалин	1,140,499.8	221,896.2
210102	Нэмэгдэл	392,694.5	60,917.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,078.0	3,833.0
210104	Урамшуулал	109,643.1	8,916.4
210105	Гэрээт ажлын хөлс	47,816.2	94,175.4

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	222,063.2	49,069.3
210201	Тэтгэврийн даатгал	154,243.9	33,631.0
210202	Тэтгэмжийн даатгал	17,154.4	3,925.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,618.0	3,122.3
210204	Ажилгүйдлийн даатгал	3,374.3	762.8
210205	Эрүүл мэндийн даатгал	33,672.7	7,627.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	268,128.1	374,241.7
210301	Гэрэл, цах илгаан	29,725.1	44,474.5
210302	Түлш, халаалт	237,483.0	328,687.2
210303	Цэвэр, бохир ус	920.0	1,080.0
2104	Хангамж, бараа материалын зардал	125,914.8	48,370.5
210401	Бичиг хэрэг	10,508.6	6,327.9
210402	Тээвэр, шатахуун	56,385.4	29,014.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,078.7	3,952.3
210404	Ном, хэвлэл	3,013.5	248.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,135.1	180.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,793.5	8,646.5
2105	Нормативт зардал	170,022.4	3,135.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,273.9	-
210502	Хоол, хүнс	71,518.8	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,229.7	3,135.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,837.2	46,880.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,380.0	5,874.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	35.0
210604	Урсгал засвар	38,457.2	40,971.9
2107	Томилолт, зочны зардал	12,110.4	14,753.3
210702	Дотоод албан томилолт	12,110.4	14,753.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	119,164.5	141,411.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	108,732.9	134,123.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,204.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,331.6	661.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	436.7	560.6
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132.0	176.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,200.0	250.0
210807	Газрын төлбөр	1,127.3	5,641.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,798.6	82,922.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,707.7	78,441.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,090.9	4,481.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,905.0	100,953.1
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	13,273.9
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	13,273.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	85,619.8	40,655.7
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,706.7	9,522.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,644.1	15,398.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,269.0	15,735.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	20.0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	20.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	49,285.2	47,003.5
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,285.2	-
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	-	47,003.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	435,325.3	438,688.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	197,948.6	201,004.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	197,948.6	201,004.4
2200	Дотоод эх үүсвэрээр	197,948.6	201,004.4
223001	Бусад хөрөнгө	120,447.8	196,233.8
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	77,500.8	4,770.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(197,948.6)	(201,004.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(64,000.0)	(114,500.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	64,000.0	114,500.0
230001	Эргэж төлөгдөх зээл	64,000.0	114,500.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	173,376.7	123,184.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	89,182.3	262,559.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	262,559.0	385,743.3

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,396,584.70	257,304.85	4,642,718.23	8,296,607.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	250.00	250.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,396,584.70	257,304.85	4,642,968.23	8,296,857.79
9	Тайлант үеийн үр дүн	-	-	109,608.66	109,608.66
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,396,584.70	257,304.85	4,752,576.90	8,406,466.45
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,396,584.70	257,304.85	4,752,576.90	8,406,466.45
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,159,537.52)	(74,043.75)	2,189,235.00	(44,346.27)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,237,047.18	183,261.10	6,941,811.90	8,362,120.18
17	Өмчид гарсан өөрчилөлт	(5,499.21)	-	-	(5,499.21)
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(878,674.58)	(878,674.58)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,231,547.97	183,261.10	6,063,137.32	7,477,946.40

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,599,812.5	1,430,077.4	169,735.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,213,575.8	1,119,343.6	94,232.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,165,279.0	1,075,271.0	90,008.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	411,305.4	389,738.8	21,566.6
210101	Үндсэн цалин	204,215.4	221,896.2	-17,680.8
210102	Нэмэгдэл	84,504.6	60,917.8	23,586.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,536.0	3,833.0	703.0
210105	Гэрээт ажлын хөлс	118,049.4	94,175.4	23,874.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,707.6	49,069.3	2,638.3
210201	Тэтгэврийн даатгал	35,701.7	33,631.0	2,070.7
210202	Тэтгэмжийн даатгал	4,039.3	3,925.5	113.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,191.6	3,122.3	69.3
210204	Ажилгүйдлийн даатгал	798.8	762.8	36.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,976.2	7,627.7	348.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	436,194.8	374,241.7	61,953.1
210301	Гэрэл, цахилгаан	42,083.3	44,474.5	-2,391.2
210302	Түлш, халаалт	391,927.5	328,687.2	63,240.3
210303	Цэвэр, бохир ус	2,184.0	1,080.0	1,104.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,294.7	45,279.5	15.2
210401	Бичиг хэрэг	6,249.1	6,247.9	1.2
210402	Тээвэр, шатахуун	26,965.6	26,965.4	0.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,844.0	3,832.3	11.7
210404	Ном, хэвлэл	250.0	248.9	1.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180.0	180.0	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,806.0	7,805.0	1.0
2105	Нормативт зардал	2,415.3	2,415.2	0.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,415.3	2,415.2	0.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,310.3	47,914.9	1,395.4
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,300.0	6,908.0	1,392.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36.8	35.0	1.8
210604	Урсгал засвар	40,973.5	40,971.9	1.6
2107	Томилолт, зочны зардал	14,770.2	14,753.3	16.9
210702	Дотоод албан томилолт	14,770.2	14,753.3	16.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,609.2	66,690.5	1,918.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,462.1	59,401.6	1,060.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	856.6	0.0	856.6
210803	Даатгалын үйлчилгээ	661.9	661.0	0.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	561.0	560.6	0.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176.0	176.0	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250.0	250.0	0.0
210807	Газрын төлбөр	5,641.6	5,641.3	0.3

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,671.5	85,167.7	503.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	81,882.0	81,378.2	503.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,789.5	3,789.5	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,296.8	44,072.6	4,224.2
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	13,293.8	13,273.9	19.9
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	13,293.8	13,273.9	19.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,003.0	30,798.7	4,204.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,708.7	9,522.0	4,186.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,398.7	15,398.7	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,895.6	5,878.0	17.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	271,219.0	196,233.8	74,985.2
223001	Бусад хөрөнгө	271,219.0	196,233.8	74,985.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	115,017.7	114,500.0	517.7
230001	Эргэж төлөгдөх зээл	115,017.7	114,500.0	517.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,599,812.5	1,458,754.4	141,058.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,480,716.3	1,391,167.7	89,548.6
320001	Орон нутгийн төсвөөс	1,254,990.2	1,165,441.7	89,548.5
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	225,726.1	225,726.0	0.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	119,096.2	67,586.7	51,509.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	67,400.6	67,086.7	313.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500.0	500.0	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	51,195.6	0.0	51,195.6
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	82,692.6	-82,692.6
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	111,369.7	-111,369.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	89,483.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	89,483.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,606.8
2104	Хангамж, бараа материалын зардал	3,091.0
210401	Бичиг хэрэг	80.0
210402	Тээвэр, шатахуун	2,049.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	120.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	841.5
2105	Нормативт зардал	720.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	720.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	800.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	800.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,304.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	74,304.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	691.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	691.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,877.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,857.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,857.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	89,483.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,483.8
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	83,431.2
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,052.6

Гурав. Аудитын илрүүлэлт: Дадал сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 4 тусгай сан, 1 орон нутгийн өмчит нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад санал дүгнэлт гаргаж 6 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургуульд аймаг дахь Төрийн аудитын газар, Хүүхдийн цэцэрлэг “ӨНДӨРХААН ИТГЭЛ АУДИТ” ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,327,017.3 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 1,717,771.1 мянган төгрөгийн 6 алдааг аудитын явцад залруулж, 576,103.5 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч ажилласан.

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 115,952.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 2,458.1 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулсан.

Аудитын илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 1,632.2 мянган төгрөгийн 1 зөрчил илэрсэн. Үүнд:

ЕБС - Шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар түүвэрлэхэд 1,632.2 мянган төгрөгийн шатахууныг дотор ажилд зарцуулсан байна.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 57,920.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн. Үүнд:

Соёлын төв 52,050.4 мянга, Цэцэрлэг 5,869.6 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй.

Шийдвэрлэлт: Байгууллага тус бүрд зөрчлийн давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 53,942.0 мянган төгрөгийн 7 зөрчил илэрсэн. Үүнд:

ЕБС - бараа материалын тайлангийн тулгалтаар 1,063.4 мянган төгрөгийн түлш, шатах, тослох материалыг анхан шатны баримтгүй зарцуулсан.

- Цалингаас суутгах шүүхийн шийдвэрийн суутгалыг суутгалгүй илүү шилжүүлсэн.

- Дотоод журамд ажилтанд төрсөн өдөр тэмдэглэх, хувийн ажлаар хот, хөдөө явахад жилд 5 хоногийн цалинтай чөлөө олгох гэж хууль тогтоомжид нийцээгүй заалтыг оруулж мөрдөн ажилласан. Цалинтай чөлөөг 5 хоногоос дээш хугацаанд өгч нийт 2,702.2 мянган төгрөгийн цалин олгосон.

Цэцэрлэг - нэг хүүхдэд ногдох хоолны зардлыг 203.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

- Эрхлэгчийн шийдвэргүйгээр 21 хүнд 2659 цагийн 22,566.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон.

- Ажиллагсдын цалинг НДШ-ийн тайланд 651.4 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн.

- Худалдан авалтын Е баримтгүй 2,613.3 мянган төгрөгийн мөнгөн зарлагын гүйлгээ хийсэн.

Шийдвэрлэсэн: Илүү цалин олгосон, анхан шатны баримтгүй зарлага гаргасан, хоолны норм хэтрүүлсэн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, эрхлэгчийн шийдвэргүй илүү цаг олгосон, цалинг НДШ -ийн тайлан дутуу мэдээлсэн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, худалдан авалтын Е баримтгүй гүйлгээ хийсэн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 11. Зөрчлийг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил								
Сургууль	3	4,387.2	3	4,387.2				
Цэцэрлэг	4	49,554.8	1	203.8	2	23,218.0	1	26,133.0
Дүн	7	53,942.0	4	4,591.0	2	23,218.0	1	26,133.0
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Соёлын төв	1	52,050.4					1	52,050.4
Цэцэрлэг	1	5,869.6					1	5,869.6
Дүн	2	57,920.0					2	57,920.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сургууль	1	1,632.2	1	1,632.2				
Дүн	1	1,632.2	1	1,632.2				
Нийт дүн	10	113,494.2	5	6,223.2	2	23,218.0	3	84,053.0

Засаг даргын санхүүгийн аудитаар 1,577,172.2 мянган төгрөгийн 2 алдаа, зөрчил илэрснээс, 1,576,405.7 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулж, 766.5 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлжээ.

3.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.3 Албан шаардлага

Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг Соёлын төвд 766.5 мянган төгрөгөөр дутуу олгосон.

3.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТТЗ	1	1,576,405.7			1	1,576,405.7	1	1,576,405.7				
ЗДТГ	1	827.3			1	827.3	1	827.3				
ИТХ	1	421.0			1	421.0	1	421.0				
ОНХС	2	95,014.8			2	95014.8	2	95014.8				
ХХС	1	45,102.3			1	45,102.3	1	45,102.3				
Дүн	6	1,717,771.1			6	1,717,771.1	6	1,717,771.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	1	766.5			1	766.5						
ИТХ	1	8,820.0			1	8,820.0						
Дүн	2	9,586.5			2	9,586.5						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ИТХ	1	33,142.7					1	33,142.7
ЗДТГ	1	566,517.0					1	566,517.0
Дүн	2	599,659.7					1	33,142.7
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	2	599,659.7					1	33,142.7

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	10	3	6	1	3			
2	ОНӨААН	1			1				
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	12	4	6	2	4			